

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 2 ДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 14 цаг 03 минутад эхэлж, 15 цаг 22 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 19 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргуулах тухай</p> <ul style="list-style-type: none">- Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга- Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Төсөл, хөтөлбөрийн хэлтсийн дарга	<p>Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none">1. Загаржавын Баянзул, Баасандоржийн Баяраа нарыг Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.2. Энэ тогтоолын нэгдүгээрт нэр заасан иргэдээс Загаржавын Баянзулыг Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтангарэлд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. <p>Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон</p>

		<p>шалгаруулах журам"-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Дангаагийн Батбаярыг Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Төсөл, хөтөлбөрийн хэлтсийн даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх</p> <p>2. Энэ тогтоолын нэгдүгээрт нэр заасан иргэн Дангаагийн Батбаярыг Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Төсөл, хөтөлбөрийн хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дарга Ц.Жадамбаад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Гадаад харилцааны яамны Гэрээ эрх зүйн газрын захирлын удирдах албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчдад Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14-ийн "а"-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 1 дүгээр сарын 23 -ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Гадаад харилцааны яамны Гэрээ эрх зүйн газрын захирлын албан тушаалд Амарсанаагийн Төмөрт дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Цогтсайханд санал болгох тухай Монгол Улсын Төрийн</p>

		<p>албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Гадаад харилцааны яамнаас Олон Улсын байгууллагын газрын захирлын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд нэр дэвшүүлж дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн материал ажлын байрны зарим шаардлагыг хангахгүй байгаа тул буцаахаар шийдвэрлэв.</p>
3	<p>Хил хамгаалах байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар батлах тухай</p>	<p>Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.8, 35 дугаар зүйлийн 35.1.3, 35.1.9, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 1.3-т заасныг баримталж, Төрийн албаны зөвлөлийн 01 дүгээр сарын 23 -ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. “Хил хамгаалах байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Хил хамгаалах байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх ороход авах мэргэшлийн шалгалтын үнэлгээ, дүн гаргах заавар”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Хил хамгаалах байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх ороход авах мэргэшлийн шалгалтын дүнгийн хуудас”-ны загварыг гуравдугаар хавсралтаар, “Хил хамгаалах байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх ороход авах мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэнийг нөөцөд бүртгэх жагсаалтын загвар”-ыг дөрөвдүгээр хавсралтаар, “Бүртгэлийн хуудасны загвар”-ыг тавдугаар хавсралтаар, “Хил хамгаалах байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх ороход авах мэргэшлийн шалгалтын зохион байгуулалтын хяналтын хуудасны загвар”-ыг зургаадугаар хавсралтаар тус тус батлах.</p>

		<p>2. Хил хамгаалах байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнийг сонгон шалгаруулахдаа энэхүү журам, зааврыг баримталж ажиллахыг Хил хамгаалах ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд үүрэг болгох.</p> <p>3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан “Хил хамгаалах байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 17 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	Газрын тосны газрын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Газрын тосны газрын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 28 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэснийг 1 дүгээр хавсралтаар батлах.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс</p>

		<p>хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 8 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 2 дугаар хавсралтаар батлах.</p> <p>3. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан нэр бүхий 8 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тус тусын албан тушаалд томилохыг Газрын тосны газрын дарга (Өлзийбүрэн)-д үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ